

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

**2025 оны 12 дугаар сарын 31-ний
өдрөөр дуусгавар болсон жилийн**

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

(Хараат бус аудиторын дүгнэлтийн хамт)

**УЛААНБААТАР ХОТ
2026 он**

Агуулга

	Хуудас
Компанийн мэдээлэл	1
Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын хариуцлагын мэдэгдэл	2
Хараат бус аудиторын дүгнэлт	3-6
Санхүүгийн байдлын тайлан	7
Ашиг, алдагдал ба усад дэлгэрэнгүй орлогын тайлан	8
Өмчийн өөрчлөлтийн тайлан	9
Мөнгөн гүйлгээний тайлан	10
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	11-43

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК

Компанийн мэдээлэл

Компани үүсгэн
байгуулагдсан
тухай:

Эрчимбаян өлгий ХК нь анх 1952 онд “Дизель станц” нэртэйгээр цахилгааны эрчим хүч үйлдвэрлэх зориулалттай байгуулагдсан. Төрийн өмчийн хорооны 2006 оны шийдвэрийн дагуу дуудлага худалдаагаар 100% хувийн өмчид шилжсэн. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн албанд 2006 оны 7-р сарын 04-ний өдөр бүртгүүлж, 2003821 тоот регистр бүхий 0210001004 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

Төлөөлөн Удирдах Зөвлөл:

А.Манси	ТУЗ-ийн дарга
У. Харашаш	ТУЗ-ийн гишүүн
А.Бейбит	ТУЗ-ийн гишүүн
Ц.Баттөмөр	ТУЗ-ийн гишүүн
М.Тилеуберди	ТУЗ-ийн гишүүн
А.Мүбарак	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Х.Ертай	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Е.Жанболат	ТУЗ-ийн хараат бус гишүүн
О. Адалбек	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гүйцэтгэх захирал

М.Тилеуберди

Албан ёсны хаяг

Монгол Улс, Баян-Өлгий, Өлгий 4-р баг, Их булан, Өөрийн байр

Хараат бус аудитор

Солид Юнити Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот 14191,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Бээжингийн гудамж,
Жи Би Плаза, 904 тоот

Санхүүгийн Тайлангийн Талаарх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл


Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Эрчимбаян өлгий ХК (цаашид “Компани” гэх)-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Удирдлага нь энэхүү 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн болохыг баталгаажуулах үүрэгтэй.

Удирдлага нь компанийн санхүүгийн тайланг тодруулга 2 ба 3-т дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах, санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөвөөр илэрхийлж чадах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бэлтгэсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн удирдлага нь компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Удирдлага нь 7-оос 43 дугаар хуудсанд илэрхийлсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийн, холбогдох бүх нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.



М.Тилеуберди
Гүйцэтгэх захирал



К.Ерболат
Ерөнхий нягтлан бодогч

Монгол Улс,
Баян-Өлгий, Өлгий 4-р баг,
Их булан, Өөрийн байр
2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр



СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хит,
14191, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Бээжингийн гудамж-24, Жи Би plaza,
9-р давхар 904 тоот

Утас: 976+99063227,
976+99091993
и-мэйл: info@solidunity.mn
web: solidunity.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Эрчимбаян өлгий ХК-ийн Хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Хязгаарлалттай дүгнэлт

Бид Эрчимбаян өлгий ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсээс бусад зүйлсийн хувьд энэхүү санхүүгийн тайлангууд нь Эрчимбаян өлгий ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (цаашид “СТОУС-ын Стандартууд” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай Дүгнэлтийн Үндэслэл

Компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тайлант жилийн эцэст тооллого хийж баталгаажуулаагүй, хөрөнгийн бодитой оршин байгааг нотлох боломжгүй, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн тайлант онд нэмэгдүүлсэн 6.4 тэрбум төгрөгийн нотлох баримтыг танилцуулаагүй ба эдгээрээс үүсэх үр нөлөө нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөлтэй байна. Мөн тайлант жилийн борлуулалтын орлого, өртгийн зарим дүн нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын “Онолын үзэл баримтлал”-ын хамааралтай байх, орлого, зардлын хүлээн зөвшөөрөлттэй нийцээгүй ба эдгээрээс үүсэх үр нөлөө нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөлтэй байна.

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид “НБЁЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм” гэх) болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Хараат бус аудиторын тайлан (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд

Тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой асуудлуудыг бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмжийг ашиглан аудитын гол асуудалд оруулсан. Бид санхүүгийн тайлангийн дүгнэлтийн хэлбэрийг сонгохдоо эдгээр асуудалд анхаарсан ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй болно. Бид дараах асуудлыг аудитын гол асуудал гэж тодорхойлсон.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно.

Санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээлэлтэй уншиж танилцан, уг мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм.

Хийж гүйцэтгэсэн ажлын хүрээнд бусад мэдээлэлд материаллаг алдаа байна гэж үзвэл энэ талаар бид тайлагнах үүрэгтэй. Жилийн тайлантай танилцах үед бусад мэдээлэлтэй холбоотойгоор бидэнд тайлагнах зүйлс байгаагүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэг, хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайланг бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, тодруулах, шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг хариуцлага хүлээнэ.

Хараат бус аудиторын тайлан (үргэлжлэл)

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан тайлан гаргах юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-н дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлж байна гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг ба бид,

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, уг эрсдэлийг үнэлэн, эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлтээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог.
- Аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүйд хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн ерөнхий тодруулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бусад

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөөлсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн талаарх мэдэгдлийг хийдэг бөгөөд шаардлагатай үед бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудлууд, хараат бус байдлын эрсдэлийг бууруулсан эсвэл түүний эсрэг авсан хамгаалалтын хариу үйлдлүүдийн талаарх мэдэгдлийг хийдэг.

Хараат бус аудиторын тайлан (үргэлжлэл)

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол асуудал хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол асуудлыг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр олон нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс уг гол асуудлыг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

Тайлан хэрэглэгчид

Энэхүү тайлан нь зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.



Солд Юнити Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот 14191,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Бээжингийн гудамж,
Жи Би Плаза 904 тоот
2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайлант хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу.

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Байдлын Тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

<i>(Тогтвор)</i>	<i>Тодруулга</i>	2025.12.31	2024.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6	99,089,453.99	817,147,575.56
Дансны болон бусад авлага	7	4,936,826,084.68	2,003,959,055.29
Татвар, шимтгэлийн авлага	8	226,875.00	14,957.92
Бараа материал	9	1,047,247,451.50	1,088,166,893.29
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	10	39,086,002.00	34,624,560.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		6,122,475,867.17	3,943,913,042.06
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	11	9,574,229,023.05	4,908,674,863.28
Биет бус хөрөнгө	12	116,666,666.99	89,719,560.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		9,690,895,690.04	4,998,394,423.28
ХӨРӨНГИЙН ДҮН		15,813,371,557.22	8,942,307,465.34
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Өр төлбөр			
Дансны болон бусад өглөг	13	916,339,768.74	364,770,708.35
Татвар шимтгэлийн өглөг	15	103,271,345.81	374,458,082.87
Богино хугацаат зээл	14	795,993,571.80	1,153,847,190.47
Урьдчилж орсон орлого		869,026.00	869,026.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн		1,816,473,712.35	1,893,945,007.69
Урт хугацаат өр төлбөр	14	3,778,721,937.44	2,630,225,401.61
Урт хугацаат өр төлбөрийн дүн		3,778,721,937.44	2,630,225,401.61
Нийт өр төлбөрийн дүн		5,595,195,649.79	4,524,170,409.30
Эздийн өмч			
Хувьцаат капитал	16	53,617,700.00	53,617,700.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц	17	10,802,167,148.74	4,363,888,720.07
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		(637,608,941.30)	630,635.97
Эздийн өмчийн дүн		10,218,175,907.43	4,418,137,056.04
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ ДҮН		15,813,371,557.22	8,942,307,465.34

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК

Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

<i>(Тогроогоор)</i>	<i>Тад- руулга</i>	2025 он	2024 он
Борлуулалтын орлого	18	7,702,785,818.38	7,430,266,072.58
Борлуулалтын өртөг	19	(7,171,582,311.60)	(6,397,118,539.80)
Нийт ашиг		531,203,506.78	1,033,147,532.78
Ерөнхий удирдлагын зардал	20	(337,214,894.94)	(258,773,559.24)
Үйл ажиллагааны ашиг		193,988,611.84	774,373,973.54
Санхүүгийн зардал	21	(746,799,401.26)	(579,505,650.66)
Бусад орлого	22	18,324,679.09	3,180,000.00
Бусад зардал	22	(104,085,966.87)	(162,115,742.52)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		332,499.93	-
Татварын өмнөх ашиг		(638,239,577.27)	35,932,580.36
Орлогын албан татварын зардал	23	-	(3,593,258.04)
Тайлант жилийн цэвэр ашиг		(638,239,577.27)	32,339,322.32
Нийт дэлгэрэнгүй ашиг (алдагдал)		(638,239,577.27)	32,339,322.32
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг		(1,190.35)	60.31

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(Тогтворлоо)	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт эздийн өмчийн дүн
	Тоо (16)	Тоо (17)		
2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	53,617,700.00	4,363,888,720.07	(31,708,686.35)	4,385,797,733.72
Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө ба алдааны залруулга	-	-	-	-
2024 оны 01-р сарын 01- нээрх үлдэгдэл	53,617,700.00	4,363,888,720.07	(31,708,686.35)	4,385,797,733.72
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	32,339,322.32	32,339,322.32
2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	53,617,700.00	4,363,888,720.07	630,635.97	4,418,137,056.04
Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө ба алдааны залруулга	-	-	-	-
2025 оны 01-р сарын 01- нээрх үлдэгдэл	53,617,700.00	4,363,888,720.07	630,635.97	4,418,137,056.04
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилт	-	6,438,278,428.66	-	6,438,278,428.66
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	(638,239,577.27)	(638,239,577.27)
2025 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	53,617,700.00	10,802,167,148.73	(637,608,941.30)	10,218,175,907.43

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Мөнгөн Гүйлгээний Тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)	2025 он	2024 он
Үндсэн үйл ажиллагаа		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого:	9,928,522,035.45	9,611,587,452.84
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	9,264,085,946.99	8,737,319,206.84
Бусад мөнгөн орлого	664,436,088.46	874,268,246.00
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага:	(11,374,523,268.03)	(10,700,677,258.78)
Ажиллагчдад төлсөн мөнгө	(1,415,213,967.56)	(1,468,970,248.18)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(402,306,123.07)	(347,023,479.60)
Бараа материал худалдан авахад төлсөн	(1,446,269,765.64)	(1,656,311,582.65)
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	(1,049,420,924.14)	(1,235,037,975.67)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	(1,202,164,820.00)	(1,685,960,309.60)
Хүүний төлбөрт төлсөн	(769,430,018.96)	(559,554,535.88)
Төлсөн татвар	(243,756,156.25)	(376,893,640.98)
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	-	(3,528,121.00)
Бусад зардалд төлсөн мөнгө	(4,842,536,090.41)	(3,367,397,365.22)
	(3,425,402.00)	-
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,446,001,232.58)	(1,089,089,805.94)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа		
Хүлээн авсан хүүний орлого	-	418,149.39
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	35,933,000.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	(7,463,000.00)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-	28,888,149.39
Санхүүгийн үйл ажиллагаа		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,149,687,602.86	2,500,000,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(421,744,491.85)	(700,543,405.40)
Бусад	-	(59,500.00)
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	727,943,111.01	1,799,397,094.60
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(718,058,121.57)	739,195,438.05
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	817,147,575.56	77,952,137.51
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	99,089,453.99	817,147,575.56

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

1. Компанийн ерөнхий мэдээлэл

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах үйл ажиллагаа юм.

Эрчимбаян өлгий ХК (цаашид компани гэх) нь 258 хувьцаа эзэмшигчидтэй, хувьцаа нь нийтэд арилжаалагддаг нээлттэй хувьцаат компани бөгөөд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны бүртгэлийн хоёрдугаар (II) ангилалд багтах компани юм

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр компанийн хувь эзэмшлийн мэдээлэл дараах байдалтай байна:

Хувьцаа эзэмшигч	Хувь
Монгол Улсын иргэн Д.Мурат	78.55%
Монгол Улсын иргэн М.Тилеуберди	14.66%
Олон нийт	6.80%
	<u>100.00%</u>

2. Санхүүгийн тайлагналын зарчим

(а) Тайлагналын нийцэл

Санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэсэн.

Санхүүгийн тайланд чухал нөлөө бүхий өндөр түвшний үнэлэмж шаардсан, нарийн төвөгтэй бөгөөд таамаглал, тооцоолол ашиглагдсан хэсгүүдийг Тодруулга 2(г)-д тодруулсан болно.

(б) Үнэлгээний суурь

Санхүүгийн тайланг холбогдох тодруулгад тусгайлан зааснаас бусад зүйлсийн хувьд түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

(в) Бүртгэлийн болон толилуулгын валют

Санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн засгийн орчны үндсэн валют болно. Тусгайлан зааснаас бусдаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг төгрөгөөр толилуулсан.

(г) Таамаглал, тооцоолол болон үнэлэмжийн хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээр үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Компани санхүүгийн тайланг бэлтгэх үед боломжтой байсан параметрууд дээр үндэслэн таамаглал, тооцоолол хийсэн. Ирээдүйн хөгжлийн талаарх одоо байгаа нөхцөл байдал, таамаглал нь зах зээлийн өөрчлөлт эсвэл компанийн хяналтаас гадуур үүссэн нөхцөл байдлын улмаас өөрчлөгдөж болно. Ийм өөрчлөлтүүд гарч ирэх үед таамаглалд тусгадаг.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

2. Санхүүгийн тайлагналын зарчим, Үргэлжлэл

(г) Таамаглал, тооцоолол болон үнэлэмжийн хэрэглээ, үргэлжлэл

Дараа жилийн санхүүгийн тайланд материаллаг залруулга хийх эрсдэл учруулахуйц таамаглал болон тооцооллын тодорхой бус асуудлын талаарх мэдээллийг доор дурдсан тодруулгын хэсэгт багтаасан.

(i) Хойшлогдсон орлогын албан татвар

Компани нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тооцоолохдоо Монгол Улсын хуулиар тогтоосон татварын хувь хэмжээ, татвараас хасагдахгүй зардлууд, татварын хуульд орсон өөрчлөлтүүд болон удирдлагын хүлээж буй ирээдүйн үр дүн зэргийг харгалзаж үздэг. Хойшлогдсон орлогын албан татварыг түр зөрүү дээр суурилан тооцоолдог ба энэ нь санхүүгийн тайланд тайлагнасан орлого, зардал болон татварын хуулийн дагуу тодорхойлсон татвар ногдох орлого, зардлын хоорондох зөрүү юм. Эдгээр түр зөрүүнээс үүссэн татварын нөлөөллийг санхүүгийн тайланд хойшлогдсон татварын хөрөнгө эсвэл өр төлбөрөөр тусгадаг.

Компанийн удирдлага нь хойшлогдсон татварын хөрөнгө хэрэгжихгүй гэж үзэж байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрдөггүй. Бодит үр дүн нь энэ таамаглалаас зөрүүтэй байх тохиолдолд ирээдүйн тайлант үеүдэд уг таамаглалын дахин тайлагнал хийх ба тайлант жилийн санхүүгийн байдал болон орлогод материаллаг нөлөө үзүүлэхүйц өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч хойшлогдсон татварын хөрөнгөөр бүртгэх шаардлага тулгарч болно.

(ii) Хөрөнгийн бодит үнэ цэнэ

Бодит үнэ цэнийн тооцоололд ашиглагдах таамаглалыг дэвшүүлэх болон дахин үнэлгээ хийх давтамжийг тодорхойлоход тодорхой хэмжээний үнэлэмж гаргах шаардлагатай байдаг.

(iii) Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа

Компанийн удирдлага нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон холбогдох элэгдлийн зардлыг тооцоолдог. Энэхүү тооцооллыг ижил шинж чанар, үүрэгтэй хөрөнгийн бодит ашиглалтын хугацаанд суурилан хийдэг.

Энэ нь техник технологийн томоохон шинэчлэл, өрсөлдөгчдийн салбарын хөдөлгөөнд үзүүлж буй хариу үйлдлийн үр дүнд их хэмжээгээр өөрчлөгдөж болно. Удирдлага өнөөгийн тооцоолсон ашиглалтын хугацаа нь өмнө нь тооцоолсон ашиглалтын хугацаанаас бага гэж үзвэл элэгдлийн зардлыг нэмэгдүүлж, эсвэл техник болон стратегийн хувьд хоцрогдсон, хаягдсан эсвэл борлуулсан хөрөнгийг данснаас хасаж эсвэл үнэ цэнийг бууруулдаг. Компанийн хөрөнгийн ашиглах хугацааг хэрхэн тодорхойлсныг тодруулга 3 (4)-өөс харна уу.

(iv) Авлагын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын нөөц

Компани авлагын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын нөөцийг харилцагч тус бүрийн бие даасан нөхцөл байдлын үнэлгээ, эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан тооцоолдог.

Энэ тохиолдолд удирдлагын үнэлгээ нь харилцагч талын нөхцөл байдал, харилцаа холбоо, түүний талаарх тодорхой байгаа зах зээлийн мэдээлэл болон зээлийн талаарх мэдээ тайлан зэрэг дээр үндэслэн хийгддэг. Компани нь цуглуулагдахаар хүлээгдэж буй дүнг илэрхийлэх үүднээс алдагдлын нөөцийг удирдлагын үнэлгээний дагуу тооцоолдог. Энэхүү тусгайлсан алдагдлын нөөцийг тооцоолсон дүнд нөлөөлөхүйц аливаа өөрчлөлт гарвал түүнийг дахин тооцон үзэж тохируулдаг.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

2. Санхүүгийн тайлагналын зарчим, Үргэлжлэл

(г) Таамаглал, тооцоолол болон үнэлэмжийн хэрэглээ, Үргэлжлэл

Үнэлгээ болон тооцоолол хийсэн аргачлалаас хамааран бүртгэсэн зардлын дүн болон хугацааны хувьд алдагдлын нөөц алгаатай байж болно. Авлагын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын нөөц өсвөл үйл ажиллагааны зардал өсөх ба эргэлтийн хөрөнгө буурах нөлөөтэй.

(v) Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолох

Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг худалдан борлуулахаар тооцоолж буй үнээс түүнийг борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм. Гэмтэлтэй, хоцрогдсон болон удаан хугацаанд хөдөлгөөнд ороогүй бараа материал байгаа эсэхийг удирдлагын зүгээс тогтмол хянадаг.

Компани өөрийн тооцооллыг үнэн зөв, бодитой гэж үзэж байгаа боловч аливаа бодит нөхцөл байдал эсвэл нөлөө бүхий хүчин зүйлсээс шалтгаалан тооцоололд өөрчлөлт орсон тохиолдолд ашиг, алдагдал болон өмчид материаллагаар нөлөө үүсэж болзошгүй.

(vi) Үйл ажиллагааны мөнгөн нэгжийг тодорхойлох

Компанид хамаарах, холбогдох нөхцөл байдлын эдийн засгийн агуулга дээр үндэслэн компанийн үйл ажиллагааны мөнгөн нэгж нь Монгол төгрөг байна гэж тодорхойлсон. Компанийн үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн үндсэн орчны мөнгөн нэгж нь монгол төгрөг ба энэ нь гол зардлуудын төлбөр хийгддэг мөнгөн нэгж юм.

(vii) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Удирдлага үнэ цэнэ бууралтын ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлохын тулд бэлэн мөнгө бий болгогч нэгж бүрийг жил болгон үнэлдэг. Хэрэв үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөн төлөгдөх дүнд албан ёсоор тооцоолол хийдэг ба энэ нь бодит үнээс борлуулах өртгийг хассан дүн ба хөрөнгийн ашиглалтын үнийн аль ихээр тодорхойлогдоно. Бодит үнэ цэнийг мэдээлэлтэй, зөвшөөрсөн талууд бизнесийг хэвийн үйл ажиллагааны гүйлгээний үед хөрөнгийг худалдан авах дүнгээр тодорхойлно. Эдгээр үнэлгээ нь урт хугацааны өргөн хэрэглээний барааны үнэ, хорогдуулалтын хувь хэмжээ, ирээдүйн капиталын хэрэгцээ шаардлага, хайгуулын боломж ба үйл ажиллагааны гүйцэтгэл зэрэг тооцоолол, төсөөлөл ашиглахыг шаарддаг.

(viii) Тасралтгүй байх зарчим

Санхүүгийн тайлан нь үйл ажиллагаагаа тасралтгүй байдлаар үргэлжлүүлэн явуулах зарчимд үндэслэн бэлтгэгдсэн бөгөөд энэ нь компани ойрын үед хөрөнгөө үйл ажиллагаандаа ашиглаж, өр төлбөрөө төлж, үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулна гэдгийг илэрхийлнэ.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан гарсан өдрөөс хойш 12 сарын хугацаанд компани ирээдүйд гарах гэрээний төлбөрүүд болон бизнесийн явцад үүсэж байдаг өр төлбөрүүдийг төлөх хангалттай хэмжээний эргэлтийн болон капиталын хөрөнгөтэй гэж үзэж байгаа бөгөөд санхүүгийн тайлан нь удирдлагын зохистой гэж үнэлсэн тасралтгүй байх зарчимд суурилан бэлтгэгдсэн.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд

Компани нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах хураангуйлсан үндсэн бодлогуудыг баримталдаг ба эдгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь тайланд тусгагдсан бүх жилүүдэд тогтвортойгоор хэрэглэгдсэн болно.

(1) Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь дуусгавар хугацаа нь худалдан авч эзэмшсэнээс хойш 3 сар болон түүнээс богино хугацаагаар тодорхойлогдсон бөгөөд бодит үнэ цэнэ өөрчлөгдөхөд өчүүхэн төдий эрсдэлийг мэдэрдэг; компанийн удирдлага богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшиж буй бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө (барьцаалсан хадгаламжийг оруулахгүй)-өөс бүрдэнэ.

(2) Санхүүгийн хэрэглүүр

(i) Хүлээн зөвшөөрөлт ба анхны хэмжилт

Авлага болон гаргасан өрийн хэрэглүүрийг анх үүсэх үед нь хүлээн зөвшөөрдөг. Бусад бүх санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрүүдийг компани тухайн хэрэглүүртэй холбоотой гэрээт тал болох үед нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгө (томоохон санхүүжилтийн бүрэлдэхүүнгүй дансны авлага биш л бол) эсвэл санхүүгийн өр төлбөрийг анхлан бодит үнэ цэнээр нь хэмжих ба худалдан авах болон гаргалттай шууд холбоотой үүссэн ажил гүйлгээний өртөг мөн хэмжилтэнд орно (ААБҮЦ-ээр хэмжигддэг зүйлсээс бусад зүйлсийн хувьд). Томоохон санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэггүй дансны авлага нь анх ажил гүйлгээний үнээр хэмжигдэнэ.

(ii) Ангилал ба дараа үеийн хэмжилт

Санхүүгийн хөрөнгө

Анхны хүлээн зөвшөөрөлтөөр санхүүгийн хөрөнгө нь дараахаар хэмжигдэнэ: БДОБҮЦ – өрийн хөрөнгө оруулалт, БДОБҮЦ – өмчийн хөрөнгө оруулалт, эсвэл ААБҮЦ.

Компани санхүүгийн хөрөнгө удирдах бизнес загвартаа өөрчлөлт оруулаагүй тохиолдолд санхүүгийн хөрөнгө нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа дахин ангилагдахгүй ба өөрчлөлт орсон тохиолдолд бүх санхүүгийн хөрөнгө нь бизнес загварын өөрчлөлтийн дараах тайлант үеийн эхний өдөр дахин ангилагдана.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(ii) Ангилал ба дараа үеийн хэмжээт, үргэлжлэл

Санхүүгийн хөрөнгө нь дараах шалгуурыг хангасан ба ААБҮЦ-ээр хэмжигддэг биш бол хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ:

- хөрөнгийг гэрээт мөнгөн урсгал цуглуулах зорилгоор эзэмшдэг бизнесийн загвартай;
- гэрээний нөхцөл нь үндсэн төлбөр дээр бодогддог хүү болон үндсэн төлбөрийн төлөлтийн мөнгөн урсгал орж ирэх өдрүүдэд нөлөө үзүүлдэг.

Санхүүгийн хөрөнгө нь дараах шалгуурт тэнцсэн ба ААБҮЦ-ээр хэмжигддэг биш бол БДОБҮЦ-ээр хэмжигдэнэ:

- хөрөнгийг гэрээт мөнгөн урсгал цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмшдэг бизнес загвартай;
- гэрээний заалт нь үндсэн төлбөр дээр бодогддог хүүгийн болон үндсэн төлбөрийн төлөлтийн мөнгөн урсгал орж ирэх өдрүүдэд нөлөө үзүүлдэг.

Борлуулах зорилгоор эзэмшээгүй өмчийн хөрөнгө оруулалтын анхны хүлээн зөвшөөрөлтийн үед компани нь эргэлт буцалтгүйгээр хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэд гарах дараа үеийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх сонголт хийж болно. Энэхүү сонголтыг хөрөнгө оруулалт тус бүрт хийж болно.

Дээр дурдсан хорогдуулсан өртөг болон БДОБҮЦ-ээр хэмжигдээгүй бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг ААБҮЦ-ээр хэмжинэ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед компани нь санхүүгийн хөрөнгө нь хорогдуулсан өртөг эсвэл БДОБҮЦ-ээр хэмжигдэх шаардлагыг хангахаас бусад үед энэхүү санхүүгийн хөрөнгийг ААБҮЦ-ээр хэмжигдэнэ гэж тодорхойлох нь нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах тохиолдолд эргэлт буцалтгүйгээр уг ангилалд оруулж болно.

Санхүүгийн хөрөнгө – Бизнесийн загварын үнэлгээ

Компани санхүүгийн хөрөнгүүдийн багцын түвшинд бизнесийн загварын үнэлгээг хийж болно. Учир нь уг түвшин удирдлагад бизнес хэрхэн удирдагдаж байгаа талаар хамгийн сайн мэдээллийг өгч чаддаг. Харгалзан үзсэн мэдээлэлд дараах зүйлс орж болно:

- багцын бодлого болон зорилтууд, мөн бодлогын практик дээрх хэрэгжилт. Үүнд, удирдлагын стратеги нь гэрээгээрх хүүгийн орлогыг цуглуулах, тодорхой хүүгийн түвшнийг хэмжээнд нь барих, санхүүгийн хөрөнгийн үргэлжлэх хугацааг холбогдох өр төлбөр эсвэл хүлээгдэж буй гадагшаа мөнгөн урсгалтай нь уялдуулах эсвэл хөрөнгийг борлуулан мөнгөн урсгал бий болгох зэргийн алинд анхаарч байгаа нь хамаарна;
- хэрхэн багцын гүйцэтгэлийг үнэлж, компанийн удирдлагад тайлагнадаг талаар;
- бизнес загварын гүйцэтгэлд нөлөөлдөг эрсдэлүүд (ба энэхүү бизнес загварт хамаарах санхүүгийн хөрөнгүүд) болон хэрхэн энэ эрсдэлүүд удирдагддаг талаар;
- бизнесийн менежерүүд хэрхэн цалинждаг талаар – жишээ нь: цалин нь удирдагдаж буй хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл гэрээгээрх мөнгөн урсгалын цуглуулсан хэмжээн дээр суурилсан эсэх; ба
- өмнөх үеийн санхүүгийн хөрөнгийн борлуулалтын давтамж, хэмжээ болон цаг хугацаа, энэхүү борлуулалтуудын шалтгаан болон ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны талаарх хүлээлт.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(2) Санхүүгийн хэрэглүүр, үргэлжлэл

(ii) Ангилал ба дараа үеийн хэмжилт, үргэлжлэл

Компанийн хөрөнгийг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрч байгаатай нийцтэй байдлаар үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагыг хангаагүй санхүүгийн хөрөнгийн гуравдагч тал руу шилжүүлсэн бол борлуулалт гэж үзэхгүй.

Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл тухайн зорилгоор удирдагддаг ба гүйцэтгэл нь бодит үнэ цэнийн сууриар үнэлэгддэг санхүүгийн хөрөнгө нь ААБҮЦ-ээр хэмжигдэнэ.

Санхүүгийн хөрөнгө – Гэрээгээрх мөнгөн урсгал нь гагцхүү үндсэн болон хүүгийн төлбөрөөс бүрддэг эсэх үнэлгээ

Энэхүү үнэлгээний зорилгоор “үндсэн төлбөр” гэдгийг санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ гэж ойлгоно. “Хүү” гэдэгт мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн төлбөр ба тодорхой цаг хугацааны үндсэн төлбөрийн зээлийн эрсдэлийн төлбөр ба бусад энгийн зээллэгийн эрсдэл болон өртөг, мөн дээр нь ашгийн хэмжээ зэрэг орно.

Гэрээгээрх мөнгөн урсгал нь гагцхүү үндсэн болон хүүгийн төлбөрөөс бүрддэг эсэхийг үнэлэхдээ, компани нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээгээрх заалтуудыг харгалзан үздэг. Үүнд, санхүүгийн хөрөнгө нь шаардлага хангах эсэхэд нөлөөлөхүйц гэрээгээрх мөнгөн урсгалын орж ирэх хугацаа эсвэл дүнг өөрчилж болох гэрээний нөхцөл агуулсан эсэхийг үнэлэх хамаарна. Энэхүү үнэлгээг хийхдээ, компани нь дараахыг харгалзан үзнэ:

- мөнгөн урсгалын хугацаа болон дүнг өөрчлөх болзошгүй үйл явдлууд;
- гэрээний нэрлэсэн үнэнд өөрчлөлт оруулж болох нөхцөлүүд, үүнд хувьсах шинж чанар бүхий зүйлс хамаарна;
- урьдчилж төлөх болон сунгах шинж чанарууд; ба
- тодорхой хөрөнгүүдээс компани мөнгөн урсгал шаардах явдлыг хязгаарлах заалтууд.

Хэрэв урьдчилгаа төлбөрийн дүн нь гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгохтой холбогдох үндэслэлтэй нэмэгдэл төлбөрийг багтаасан байх магадлалтай зээлийн үндсэн төлбөрийн төлөгдөөгүй үндсэн болон хүүгийн төлбөрийн дүнг илтгэж байвал уг урьдчилгаа төлбөрийн шинж чанарыг үндсэн болон хүүгийн төлбөр хэмээх шаардлагатай нийцэлтэй гэж үзнэ.

Мөн хөнгөлөлттэй болон гэрээгээрх нэрлэсэн үнэ дээрээс нэмэлтээр худалдан авсан санхүүгийн хөрөнгийн хувьд, гагцхүү гэрээт үнэ болон хойшлуулсан (төлөгдөөгүй) хүү (гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгохтой холбоотой төлбөрийг агуулж болно) зэргийг илтгэх урьдчилгааг зөвшөөрдөг эсвэл шаарддаг шинж чанарыг, урьдчилгааны бодит үнэ цэнэ нь анхны хүлээн зөвшөөрөлт дээр мэдэгдэхүйц их дүнгэй биш тохиолдолд мөн дээрх шаардлагатай нийцэлтэй гэж үзнэ.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(2) Санхүүгийн хэрэглүүр, үргэлжлэл

(ii) Ангилал ба дараа үеийн хэмжилт, үргэлжлэл

Санхүүгийн хөрөнгө – Дараа үеийн хэмжилт болон олз ба гарз

ААБҮЦ-ээр санхүүгийн хөрөнгө	Энэхүү хөрөнгийг дараа үед бодит үнэ цэнээр нь хэмждэг. Аливаа хүү болон ногдол ашгийн орлого зэргийг агуулсан олз ба гарз нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөгдөнө.
Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг санхүүгийн хөрөнгө	Энэхүү хөрөнгийг дараа үед үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хорогдуулсан өртөг нь үнэ цэнийн бууралтын гарзаар буурна. Хүүгийн орлого, гадаад валютын олз ба гарз болон үнэ цэнийн бууралт зэрэг нь ашиг ба алдагдалд хүлээн зөвшөөрөгдөнө. Данснаас хасах үед үүсэх олз ба гарз нь ашиг ба алдагдалд хүлээн зөвшөөрөгдөнө.
БДОБҮЦ-ээр хэмжигддэг өрийн хөрөнгө оруулалтууд	Энэхүү хөрөнгийг дараа үед бодит үнэ цэнээр хэмждэг. Үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолсон хүүгийн орлого, гадаад валютын олз ба гарз болон үнэ цэнийн бууралт зэрэг нь ашиг ба алдагдалд хүлээн зөвшөөрөгдөнө. Бусад цэвэр олз ба гарз нь бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдөнө. Данснаас хасах үед бусад дэлгэрэнгүй орлогод хуримтлагдсан олз ба гарз нь ашиг, алдагдал руу дахин ангилагдана.
БДОБҮЦ-ээр хэмжигддэг өмчийн хөрөнгө оруулалтууд	Энэхүү хөрөнгийг дараа үед бодит үнэ цэнээр хэмждэг. Ногдол ашиг нь хөрөнгө оруулалтын өртгийн нөхөлтийг илэрхий илтгээгүй бол ашиг, алдагдалд орлого байдлаар хүлээн зөвшөөрөгдөнө. Бусад цэвэр олз ба гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх ба хэзээ ч ашиг, алдагдал руу дахин ангилахгүй.

Санхүүгийн өр төлбөр – Ангилал, дараа үеийн хэмжилт болон олз, гарз

Санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр эсвэл ААБҮЦ-ээр хэмжигдэх гэж ангилдаг. Санхүүгийн өр төлбөр нь арилжих зорилгоор эзэмшдэг, үүсмэл эсвэл эхний хүлээн зөвшөөрөлтөөс тухайн сонголтыг хийсэн бол БДОБҮЦ-ээрх ангилалд багтана. БДОБҮЦ-ээрх санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнэ болон хүүгийн зардлыг багтаасан цэвэр олз, гарзын нийлбэрээр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Бусад санхүүгийн өр төлбөрийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хүүгийн зардал болон гадаад валютын олз ба гарзыг ашиг, алдагдал хүлээн зөвшөөрнө.

(iii) Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээнд хамаарах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан эсвэл уг санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бодитойгоор шилжүүлсэн бол уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг. Уг гүйлгээгээр бий болсон эсвэл үлдсэн аливаа эрх, үүргийг тусад нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Хэрэв компани уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бодитойгоор өөртөө үлдээсэн бол уг санхүүгийн хөрөнгийг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөх ба холбогдох санхүүгийн өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрдөг.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(2) Санхүүгийн хэрэглүүр, үргэлжлэл

(iii) Үл хүлээн зөвшөөрөлт Үргэлжлэл

Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг холбогдох үүрэг хариуцлага биелсэн, хүчингүй болсон эсвэл хугацаа нь дууссан тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ.

Анхны санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба төлсөн дүн (мөнгөн бус хөрөнгө хүлээн авах болон өр төлбөр хаах зэргийг багтаасан) хоёрын зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Цэвэр дүнгээр нь тусгах

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь нэгтгэж, цэвэр дүнгээр нь илэрхийлэх нь хууль эрх зүйн үндэслэлтэй, цэвэр дүнгээр төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулж, өр төлбөрийг барагдуулах зорилготой санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэн санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

(3) Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардлууд ордог. Үйлдвэрийн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн хувьд хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг өртөгт хуваарилдаг.

Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүнг хэлнэ.

(4) Үндсэн хөрөнгө

(i) Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анхны удаа өртгөөр нь хэмждэг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг. Өөрийн хөрөнгөөр барьж байгуулж буй хөрөнгийн өртөгт дараах зүйлс орно:

- Шууд материал болон шууд хөдөлмөрийн зардал;
- Хөрөнгийг зориулалтаар нь ашиглахад бэлэн болгохтой шууд холбоотой гарах бусад зардлууд; болон
- Хөрөнгийг барьж байгуулахтай холбогдон гарах зээлийн өртөг

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(4) Үндсэн хөрөнгө, үргэлжлэл

(ii) Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжээт

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэний бууралтын гарзыг хассан дүн байдаг. Хөрөнгийн бодит үнэ цэнийг хараат бус гуравдагч этгээд тогтоодог.

Хэрэв дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ өссөн байвал энэ өсөлтийг тухайн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг буцааж өмнөх ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн хэмжээгээр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бусад бүх тохиолдолд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгаж, өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэнэ. Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан байвал тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээс давсан бууралтыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Дахин үнэлгээ хийсэн өдрөөрх хуримтлагдсан элэгдлийг тухайн хөрөнгийн нийт дансны үнэтэй цэвэрлэдэг бөгөөд дансны цэвэр дүн нь хөрөнгийн дахин үнэлэгдсэн дүнгээр дахин илэрхийлэгддэг.

Үндсэн хөрөнгийн зүйлсийг борлуулснаас үүссэн олз, гарзыг үндсэн хөрөнгийн дансны үнэ болон цэвэр борлуулалтын орлогын зөрүүгээр тодорхойлдог. Дахин үнэлэгдсэн хөрөнгийг борлуулсан эсвэл ашиглалтаас хассан тохиолдолд дахин үнэлгээний нөөцөөс ногдох дүн нь хуримтлагдсан ашиг руу шилждэг.

Тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшил болон бусад үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан өртгөөр хэмжинэ.

(iii) Дараа үеийн зардлууд

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

(iv) Элэгдэл

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, ашиг, алдагдлаар бүртгэдэг. Түрээсийн хөрөнгийн хувьд хэрэв түрээслэгч нь түрээсийн хугацааны эцэст хөрөнгийн өмчлөлийн эрхийг авах нь тодорхой биш бол тухайн хөрөнгийг түрээсийн хугацаанд нь эсвэл түүнийг ашиглахаар тооцсон хугацааны аль богино хугацаагаар нь элэгдүүлдэг.

Үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь, дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг.

Үндсэн хөрөнгийн зүйлсийн тайлант жил болон харьцуулсан жилд тооцсон эдийн засгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(4) Үндсэн хөрөнгө, үргэлжлэл

(iv) Эгзэгдэл Үргэлжлэл

	Ашиглагдах жил
Барилга, байгууламж	8-60 жил
Машин тоног төхөөрөмж	4-15 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга, эд хогшил	1-11 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	4-10 жил

Хөрөнгийн элэгдэл байгуулах арга, ашиглахаар тооцсон хугацаа болон үлдэх өртгийг тайлант жил бүрийн эцэст дахин хянаж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийдэг.

(5) Биет бус хөрөнгө

(i) Хүлээн зөвшөөрөх үеийн хэмжээ

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй биет бус хөрөнгийн зүйлсийг анх дансанд өртгөөр нь хэмжиж хүлээн зөвшөөрдөг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

(ii) Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжээ

Компанийн худалдан авсан тодорхой ашиглах хугацаатай биет бус хөрөнгийг түүний өртгөөс хуримтлуулсан хорогдуулга болон үнэ цэний бууралтыг хассан цэвэр дүнгээр хэмждэг.

(iii) Дараа үеийн зардлууд

Дараа үеийн зардлыг зөвхөн холбогдох хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай үед капиталжуулдаг. Бусад бүх зардлыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

(iv) Хорогдуулга

Биет бус хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар хорогдуулж, ашиг алдагдлаар зөвшөөрдөг. Биет бус хөрөнгийн зүйлсийн тайлант жил болон түүнтэй зэрэгцүүлэх хугацаанд тооцсон эдийн засгийн ашиглах хугацаа дараах байдалтай байна.

	Ашиглагдах хугацаа
Патент	30 жил

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нийтлэн бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(6) Үнэ цэнийн бууралт

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүд

Санхүүгийн хэрэглүүр ба гэрээгээрх хөрөнгө

Компани хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг дараах хөрөнгүүдэд байгуулдаг:

- хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө; болон
- БДОБУЦ-ээр хэмжсэн өрийн хөрөнгө оруулалт.

Компани алдагдлын санг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмжсэн дараахаас бусад хөрөнгийн хувьд уг хөрөнгийн эзэмших эрх дуусах хүртэлх хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг хэмждэг. Үүнд:

- тайлангийн өдрөөр хүлээгдэж буй эрсдэлийг бага гэж тодорхойлсон өрийн үнэт цаас; болон
- анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүсээгүй бусад өрийн үнэт цаас болон банкны үлдэгдэл

Авлагын болон гэрээгээрх хөрөнгийн алдагдлын санг үргэлж хөрөнгийн хувьд уг хөрөнгийн эзэмших эрх дуусах хүртэлх хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмждэг.

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн санхүүгийн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүссэн эсэхийг тодорхойлж, хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг тооцохын тулд Компани нь холбоотой бөгөөд аливаа нэмэлт зардал эсвэл хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломж бүхий үндэслэлтэй бөгөөд нотлогдохуйц мэдээллүүдийг харгалзан үздэг. Үүнд, Компанийн түүхэн мэдээлэлд үндэслэн чанарын болон тоон үзүүлэлтэд шинжилгээ хийх, мэдээлсэн эрсдэлийн үнэлгээ болон ирээдүйн тоон мэдээлэл зэргийг харгалзан үзэх хамаарна.

Компани нь 30 хоногоос илүү хугацаа хэтрэлттэй санхүүгийн хөрөнгийн хувьд санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэл нь ихээр өссөн гэж үзнэ.

Компани нь дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийн үүргийн биелэлт хангагдаагүй (дефолт) гэж үзнэ:

- компанийн зүгээс барьцааг суллах (хэрвээ байгаа бол) гэх мэт арга хэмжээ аваагүй үед зээлдэгч нь өөрийн зээлийн үүргээ Компанид бүрэн биелүүлэхгүй байх магадлалтай тохиолдолд; эсвэл
- санхүүгийн хөрөнгө 90 хоногоос илүү хугацаа хэтрэлттэй.

Ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал гэдэг нь ашиглалтын хугацааны туршид бүхий л дефолт болох боломжит үйл явдлуудын хүлээгдэж буй алдагдлын хувийг илэрхийлнэ.

12 сарын хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал гэдэг нь тайлагналын өдрийн дараах 12 сарын хугацааны туршид (хэрвээ санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй ашиглалтын хугацаа нь 12 сараас бага тохиолдолд тайлагналын дараах хугацаа нь бага байж болно) үүргийн биелэлт хангагдахгүй болох боломжит үйл явдлуудын хүлээгдэж буй алдагдлын хувийг илэрхийлнэ.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(6) Үнэ цэнийн бууралт, үргэлжлэл

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүд, үргэлжлэл

Компани хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг тооцоолох хугацаа нь хамгийн ихдээ гэрээний нөхцөл дэх зээлийн эрсдэлийн хугацаа байдаг.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжээ

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал гэдэг нь зээлийн алдагдлын хүлээгдэж буй жигнэсэн үнэлгээ юм. Зээлийн алдагдлыг бүх мөнгөний дутагдлын өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ. Мөнгөний дутагдал гэдэг нь Компанийн зүгээс хүлээгдэж буй мөнгөн урсгал болон гэрээний дагуу үүссэн мөнгөн урсгалын зөрүү юм.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлыг санхүүгийн хөрөнгийн үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр хорогдуулдаг.

Үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүд

Компани нь хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ нь буурсан эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Санхүүгийн хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалын тооцоололд сөргөөр нөлөөлөх нэг буюу түүнээс олон үйл явдал гарсан тохиолдолд үнэ цэнэ нь буурсан гэж үзнэ. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан нотолгоонд дараах ажиглагдахуйц тоо баримтууд агуулагдана:

- зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдал;
- гэрээ зөрчсөн эсвэл 90 хоногоос илүү хугацаа хэтрэлттэй;
- компани нь зээл, урьдчилгаанд нөхцөлтэйгөөр бүтцийн өөрчлөлт оруулах;
- зээлдэгч нь дампуурах эсвэл түүнд санхүүгийн бүтцийн өөрчлөлт орох магадлалтай байх; эсвэл
- санхүүгийн хүндрэлээс болж үнэт цаасыг арилжих идэвхтэй зах зээл байхгүй болох

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг санхүүгийн байдлын тайланд толилуулах

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн алдагдлын санг хөрөнгийн дансны үнээс хасдаг. БДОБҮЦ-ээр хэмжсэн өрийн үнэт цаасны алдагдлын санг ашиг, алдагдлаар бүртгэх ба бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрдөг.

Данснаас хасах

Компани санхүүгийн хөрөнгийг бүтнээр эсвэл ямар нэг хэсгийг нь буцаан олох үндэслэлтэй хүлээлт байхгүй болсон үед холбогдох санхүүгийн хөрөнгийн нийт үлдэх өртгөөр нь данснаас хасна. Байгууллагын харилцагчдын хувьд, тухайн хөрөнгө нөхөгдөх үндэслэлтэй хүлээлт байгаа эсэх үнэлгээнд суурилан данснаас хэзээ, ямар дүнгээр хасахтай холбоотой үнэлгээг Компани гүйцэтгэдэг. Компани данснаас хассан дүнгийн хувьд буцаан нөхөгдөх боломжтой гэсэн үндэслэлтэй хүлээлтгүй байна.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(6) Үнэ цэнийн бууралт, үргэлжлэл

(ii) Санхүүгийн бус хөрөнгө

Бараа материал болон хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад Компанийн санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэд хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолдог. Ашиглалтын хугацааг нь тодорхойлох боломжгүй эсвэл одоогоор ашиглагдах боломжгүй гүүдвилл болон биет бус хөрөнгийн нөхөгдөх дүнг жил бүрийн ижил үед шалгадаг.

Мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн хувьд нөхөгдөх дүн нь мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь байдаг. Ашиглалтын үнэ цэнийг тооцохдоо хөрөнгийн хувьд онцлог эрсдэл болон мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх хувь хэмжээг ашиглан хөрөнгийг тасралтгүй ашигласнаас болон ашиглагдахаар тооцсон хугацааны эцэст данснаас хасах үед үүсэхээр хүлээгдэж буй тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр хэмждэг. Үнэ цэнийн бууралтын гарзыг хөрөнгө эсвэл мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн үед хүлээн зөвшөөрдөг. Үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

(7) Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж, урамшуулал

(i) Тодорхой шимтгэл бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр

Хуулийн дагуу Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

(8) Гадаад валютаар хийгдсэн гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж, төгрөг валютаар давхар бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар төгрөг руу хөрвүүлэн илэрхийлнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар үйл ажиллагааны валют руу хөрвүүлэн илэрхийлдэг.

Борлуулах боломжтой өмчийн хэрэглүүрийн дахин хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүнээс бусад тохиолдолд гадаад валютын дахин хөрвүүлэлтийн ханшийн зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч, санхүүгийн өр төлбөрийг гадаад үйл ажиллагаа дахь цэвэр хөрөнгө оруулалтын баталгаа болгон эсвэл бусад дэлгэрэнгүй орлогын тайланд мөнгөн урсгалын баталгаа болгон хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшаар тайлагнадаг.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(9) Нөөц ба болзонгүй өр төлбөр

Компани нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

Нөөцийн хамгийн сайн тооцооллыг хийхийн тулд үйл явдал, нөхцөл байдлын хүрээлэн байгаа эрсдэл, тодорхойгүй байдал зэргийг харгалзаж үзэх ёстой. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтэй бол нөөцийн дүн нь ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ байдаг.

Нөөцийн төлбөрийг барагдуулахад шаардагдах зарлагыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь өөр нэг талаас нөхөн авахаар хүлээгдэж байгаа үед, хэрэв Компани үүрэг хариуцлагынхаа дагуу төлбөрийг барагдуулсан үед нөхөн олговор хүлээн авах нь тодорхой байх нөхцөлд л зөвхөн нөхөн олговрыг хүлээн зөвшөөрөх ёстой. Нөхөн олговрыг тусад нь хөрөнгө гэж үздэг.

Нөөцийн дүнг тайлангийн хугацааны эцэс бүрд шалгаж, тайлангийн үеийн хамгийн сайн тооцооллыг тусгахын тулд тохируулж байдаг. Хэрэв үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн гадагшлах урсгал нь магадлал багатай бол нөөцийн дүнг буцаадаг.

(10) Орлого хүлээн зөвшөөрөлт

Компани нь 5 алхамт арга хандлагыг хэрэгжүүлсэн:

- Алхам 1: Харилцагчтай байгуулсан гэрээг тодорхойлох
- Алхам 2: Гэрээний тусдаа гүйцэтгэлийн үүргүүдийг тодорхойлох
- Алхам 3: Ажил гүйлгээний үнийг тодорхойлох
- Алхам 4: Ажил гүйлгээний үнийг тусдаа гүйцэтгэлийн үүргүүдэд хуваарилах
- Алхам 5: Гүйцэтгэлийн үүрэг бүр хангагдсан үед орлогыг хүлээн зөвшөөрөх

“Гэрээ” гэдэг нь хоёр ба түүнээс дээш этгээдийн хооронд хүчин төгөлдөр эрх болон үүрэг үүсэх үйл явц юм. СТОУС 15-ын хүрээнд харилцагчтай байгуулсан гэрээ нь хуулийн дагуу хүчин төгөлдөр бөгөөд мөн дараах бүх шаардлагыг хангасан байхыг хэлнэ:

- Гэрээ нь батлагдсан ба талууд гэрээгээрх хүлээсэн үүргээ ухамсарласан;
- Бараа эсвэл үйлчилгээг эзэмших эрх болон төлбөрийн нөхцөлийг тодорхойлох боломжтой;
- Гэрээ нь арилжааны шинж чанартай; ба
- Гэрээний төлбөрийг цуглуулах магадлалтай.

Харилцагчид хүрэх үйлчилгээг гэрээнд тодорхой заасан байх ба гүйцэтгэлийн үүрэг гэж үзнэ.

Ажил гүйлгээний үнэ нь гэдэг нь компани үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлсний төлөө авах төлбөрийн хэмжээ юм.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(11) Хувьцаат капитал

(i) Энгийн хувьцаа

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

(ii) Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь компанийн өмчийн эздэд ногдох ашгаас зарласан ногдол ашгийг хассан дүн болно. Стандартад шилжилтийн шаардлагын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс үүссэн нөлөөллийг хуримтлагдсан ашигт бүртгэдэг.

(iii) Дахин үнэлгээний нэмэгдлийн ноц

Компани үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн бол бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн өсөлтийн дүнг энэ дансанд хуримтлуулан бүртгэнэ. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү - өсөлт, үнэ цэний бууралтын гарзын буцаалтын дүнгээр нэмэгдүүлнэ. Харин бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү - бууралт, үнэ цэний бууралтын гарз, хэрэгжсэн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээр энэ дансыг бууруулна.

(12) Санхүүгийн орлого ба санхүүгийн зардал

Санхүүгийн орлого нь хөрөнгө оруулалтаас хүлээн авсан хүүгийн орлого, борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө борлуулснаас олсон олз, ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлт, гадаад валютын олз зэргээс бүрдэнэ. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан дэлгэрэнгүй орлогын тайланд хуримтлуулан хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардал, нөөцийн хөнгөлөлтийн буцаалт, ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлт болон гадаад валютын гарз зэргээс бүрдэнэ. Зээлийн хүүгийн зардлуудыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан, дэлгэрэнгүй орлогын тайланд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

(13) Орлогын албан татвар

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(13) Орлогын албан татвар, үргэлжлэл

(i) Тайлант үеийн татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохируулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм. Татвар ногдох ашгийг тооцохдоо ирээдүйн тайлант үеийн татвар ногдох ашиг (татварын алдагдал)-ийг тодорхойлоход хэрэглэгдэх татвар ногдох орлого эсвэл татвараас хасагдах зардлаар тооцогдох түр зөрүү, мөн нягтлан бодох бүртгэлийн ашгийн татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардал зэргийг харгалзан үздэггүй учраас татвар ногдох ашиг нь нягтлан бодох бүртгэлийн ашгаас ялгаатай байдаг.

(ii) Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг хөрөнгө, өр төлбөрийн аргыг ашиглан хүлээн зөвшөөрч бүртгэдэг бөгөөд энэ арга нь санхүүгийн тайлангийн зорилгоор хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татварын зорилгоор ашиглагдах дүн хоёрын хоорондох түр зөрүүнд үндэслэдэг. Бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Хэрэгжүүлэхүйц татвар ногдуулах орлого олох боломжтой хүрээнд хасагдах бүх түр зөрүүний хувьд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Гэхдээ дараах түр зөрүүнүүдэд хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрөхгүй: гүүдвиллийн анхдагч хүлээн зөвшөөрөлт, эсвэл бизнесийн нэгдэл биш бөгөөд ажил гүйлгээ гарах үед нягтлан бодох бүртгэлийн ашиг болон татвар ногдох ашиг/татварын алдагдлын аль алинд нөлөөлөхгүй ажил гүйлгээн дэх хөрөнгө буюу өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт. Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэс бүрд дахин хянаж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг хүртэх хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал үгүй болох үед компани хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хэмждэг. Тайлант үеийн эцэст компани нь хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах арга хэлбэрээс үүсэж байгаа татварын үр нөлөөг хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилтэд тусгадаг.

(ii) Хойшлогдсон татвар, үргэлжлэл

Компани нь тайлант үеийн татварын өр төлбөрийг тайлант үеийн татварын хөрөнгөөр суутган тооцох хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй байх, орлогын татвараар тооцоо хийдэг ижил татварын албатай харьцдаг ба тайлант үеийн татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр сууриар барагдуулахаар төлөвлөсөн тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр дүнгээр тооцдог. Хэрэв ногдол ашиг төлөлттэй холбоотойгоор нэмэлт орлогын албан татварын зардал үүссэн бол уг орлогын албан татварын зардлыг ногдол ашгийн төлөлттэй холбоотой өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх үед орлогын албан татварын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, Үргэлжлэл

(14) Тайлагналын дараах үйл явдал

Компанийн тайлант өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тухай нэмэлт мэдээллээр хангах жилийн эцсийн дараах үйл явдлууд (залруулах үйл явдал) нь санхүүгийн тайланд тусгагдсан. Залруулах шаардлагагүй жилийн эцсийн дараах үйл явдал нь материаллаг бол санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулсан.

(15) Холбоотой талууд

- (i) Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотнын гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:
- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг
 - Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй
 - Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

- (ii) Дараах нөхцөлүүдийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгж компанитай холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон компани нь нэг группийн бүрэлдэхүүнд багтаж байвал (өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид хамаардаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой);
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хяналттай компани бол (эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан группийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтын хяналттай компани бол);
- Хоёр аж ахуйн нэгж хоёулаа гуравдагч талын хамтын хяналттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч талын хамтын хяналттай компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч талын хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь компани эсвэл түүнтэй холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжид зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө бол;
- (i)- тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид хяналт тавьдаг эсвэл хамтран хянадаг бол;
- (i)-д тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл уг аж ахуйн нэгж (эсвэл түүний толгой компанийн)-ийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотнын гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

4. Тайлант хугацаанд мөрдөгдөж эхэлсэн нягтлан бодох бүртгэлийн шинээр гарсан стандартууд болон стандартын нэмэлт өөрчлөлтүүд

Дараах стандартын нэмэлт өөрчлөлтүүд 2025 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн боловч компанид мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй байна.

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2025 оны 01 дүгээр сарын 01	• Арилжаалагдах боломж бага – НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлтүүд

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

5. Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй СТОУС, Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Нягтлан бодох бүртгэлийн хэд хэдэн шинэ стандартууд нь 2026 оны 01 дүгээр сарын 01-ээс хойших тайлант жилүүдэд хэрэгжиж эхлэх бөгөөд мөрдөгдөж эхлэх хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн. Гэхдээ Компани санхүүгийн тайланг бэлтгэхдээ дараах шинэ эсвэл нэмэлт өөрчлөлт орсон стандартуудыг хэрэгжүүлж эхлээгүй байна.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх огноо	Нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2026 оны 01 дүгээр сарын 01	- Санхүүгийн хэрэглүүрийн ангилал ба хэмжилт – СТОУС 9 болон СТОУС 7-ийн нэмэлт өөрчлөлтүүд - СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын жил бүрийн сайжруулалт – 11-р хэвлэл
2027 оны 01 дүгээр сарын 01 Сонголттойгоор мөрдөх боломжтой / мөрдөх хугацааг тодорхойгүйгээр хойшлуулсан	- СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга - СТОУС 19 Олон нийтийн үүрэг хариуцлага хүлээгээгүй охин компаниуд: Тодруулга - Хөрөнгө оруулагч болон түүний хараат эсвэл хамтарсан компани хоорондын борлуулалт болон хувь оруулсан хөрөнгө – СТОУС 10 болон НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлтүүд

СТОУС 18 Санхүүгийн Тайлангийн Толилуулга ба Тодруулга

2027 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэх болон түүнээс хойших тайлант жилүүдэд СТОУС 18 нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартыг орлоно. Шинэ стандартаар дараах үндсэн шинэ шаардлагуудыг танилцуулсан.

- Компаниуд бүх орлого, зардлыг ашиг, алдагдлын тайланд үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, санхүүжилт, зогсоосон үйл ажиллагаа болон орлогын татвар гэсэн таван үндсэн төрөлд ангилах шаардлагатай. Компаниуд мөн шинээр тодорхойлсон үйл ажиллагааны ашгийн дүнг толилуулах шаардлагатай болсон. Компанийн цэвэр ашгийн дүн өөрчлөгдөхгүй.
- Удирдлагын тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүр (“УТГХ”) нь санхүүгийн тайланд тусдаа тодруулгаар толилуулагдана.
- Санхүүгийн тайланд мэдээллийг хэрхэн бүлэглэх талаар дэлгэрэнгүй удирдамж гарсан.

Түүнээс гадна, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг шууд бус аргаар толилуулж байгаа тохиолдолд компаниуд мөнгөн гүйлгээний тайланг үйл ажиллагааны ашгийн дүнгээс эхлэх шаардлагатай.

Компани шинэ стандартын, ялангуяа Компанийн ашиг, алдагдлын тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн бүтэц болон УТГХ-ээр шаардсан нэмэлт тодруулгын нөлөөг үнэлэх шатандаа явж байна. Мөн Компани санхүүгийн тайлангийн мэдээллийг хэрхэн цаашид бүлэглэх, тэр дундаа одоогоор 'бусад' гэж тэмдэглэсэн зүйлүүдэд үзүүлэх нөлөөллийг үнэлж байна

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

6. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

(i) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

<i>(Төгрөгөөр)</i>	2025 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Касс дахь бэлэн мөнгө	6,798,770.20	26,422,720.00
Харилцах дахь мөнгөн хөрөнгө	92,290,683.79	790,724,855.56
Мөнгөн хөрөнгийн дансны үнэ	99,089,453.99	817,147,575.56
Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	-	-
Мөнгөн хөрөнгийн цэвэр дансны дүн	99,089,453.99	817,147,575.56

7. Дансны авлага

(i) Дансны авлагын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

<i>(Төгрөгөөр)</i>	2025 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Дансны авлага-Аж ахуй нэгж	526,914,582.28	219,940,836.09
Дансны авлага-Төсөвт байгууллага	1,057,095,381.17	1,552,022,321.35
Дансны авлага-Айл өрх	130,489,658.50	92,404,861.99
Нийт дансны цэвэр дүн	1,714,499,621.95	1,864,368,019.43

(i) Бусад авлагын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

<i>(Төгрөгөөр)</i>	2025 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
Бусад авлага		
Ажилтдаас авах авлага	91,274,082.80	62,020,629.06
Бусад авлага	3,131,052,379.93	77,570,406.80
Бусад авлагын дүн	3,222,326,462.73	139,591,035.86
Дансны болон бусад авлагын дүн	4,936,826,084.68	2,003,959,055.29

Бусад авлагын дансны 41.6 хувь буюу 1.3 тэрбум төгрөг нь холбоотой талаас авах авлага байна.

8. Татвар, шимтгэлийн авлага

(i) Татвар шимтгэлийн авлага нь дараах данс ангиллаас бүрдэж байна:

<i>(Төгрөгөөр)</i>	2025 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
НДШ-ийн авлага	226,875.00	14,957.92
Татвар шимтгэлийн авлагын дүн	226,875.00	14,957.92

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

9. Бараа материал

(i) Бараа материалын 2024 болон 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл дараах байдалтай байна.

<i>(Төгрөгөөр)</i>	2025 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
Хангамжийн материал	18,803,820.00	23,053,947.50
Сэлбэг хэрэгсэл	879,858,338.50	800,707,329.79
Бичиг хэргийн материал	6,510,400.00	4,866,650.00
Хөдөлмөр хамгааллын материал	34,214,123.00	43,733,602.00
Шатах төслөх материал	11,520,630.00	11,738,500.00
Нүүрс	96,340,140.00	204,066,864.00
Бараа материалын дүн	1,047,247,451.50	1,088,166,893.29

10. Урьдчилж төлсөн зардал, тооцоо

(i) Урьдчилж төлсөн зардал, тооцооны дансны дүн дараах байдалтай байна:

<i>(Төгрөгөөр)</i>	2025 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа төлбөр	39,086,002.00	34,624,560.00
Урьдчилж төлсөн тооцооны дүн	39,086,002.00	34,624,560.00

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

11. Үндсэн хөрөнгө

(i) Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр:

Өртөг	Барилга, байгууламж	Машин, тоног тохөөрөмж	Тавилга эд хөгшил	Тээврийн хэрэгсэл	Компьютер дагалдах хэрэгсэл	Нийт
2025 оны 01-р сарын 01-ээр	6,393,126,516.08	1,358,782,398.70	187,514,549.63	562,917,261.75	50,393,200.00	8,552,733,926.16
Нэмэгдсэн	10,168,760,967.11	55,143,200.00	47,075,835.37	139,825,468.25	17,845,400.00	10,428,650,870.72
Хасагдсан	-	147,521,180.22	3,739,150.00	12,838,000.00	7,378,900.00	171,477,230.22
2025 оны 12-р сарын 31-ээр	16,561,887,483.19	1,266,404,418.48	230,851,234.99	689,904,730.00	60,859,700.00	18,809,907,566.66
Хуримтлагдсан элэгдэл						
2025 оны 01-р сарын 01-ээр	2,294,336,698.93	1,076,494,739.18	71,263,986.62	184,190,107.16	17,773,530.99	3,644,059,062.88
Тухайн жилийн элэгдэл	5,593,682,292.24	-	30,363,566.49	145,578,141.24	28,367,421.61	5,797,991,421.58
Данснаас хассан	-	193,117,711.70	2,281,305.72	6,150,050.01	4,822,873.42	206,371,940.85
2025 оны 12-р сарын 31-ээр	7,888,018,991.17	883,377,027.48	99,346,247.39	323,618,198.39	41,318,079.18	9,235,678,543.61
Дансны нэвэр дүн	8,673,868,492.02	383,027,391.00	131,504,987.60	366,286,531.61	19,541,620.82	9,574,229,023.05

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

14. Үндсэн хөрөнгө Үргэлжлэл

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй 2024 оны 12-р сарын 31-ээр өдрөөр:

Өртөг	Барилга, байгууламж	Машин, тоног техөөрөмж	Тавилга эд хогшил	Тээврийн хэрэгсэл	Компьютер дагалдах хэрэгсэл	Нийт
2024 оны 01-р сарын 01-ээр	5,273,898,626.23	1,356,298,598.70	133,777,967.34	310,494,686.75	31,524,400.00	7,105,994,279.02
Нэмэгдсэн	1,119,227,889.85	2,483,800.00	53,907,430.00	252,422,575.00	18,868,800.00	1,446,910,494.85
Хасагдсан	-	-	170,847.71	-	-	170,847.71
2024 оны 12-р сарын 31-ээр	6,393,126,516.08	1,358,782,398.70	187,514,549.63	562,917,261.75	50,393,200.00	8,552,733,926.16
Хуримтлагдсан элэгдэл						
2024 оны 01-р сарын 01-ээр	2,083,079,542.70	946,571,944.70	49,530,965.05	140,462,343.67	11,060,859.95	3,230,705,656.07
Тухайн жилийн элэгдэл	211,257,156.23	129,922,794.48	21,733,021.57	43,727,763.49	6,712,671.05	413,353,406.81
Данснаас хаассан	-	-	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ээр	2,294,336,698.93	1,076,494,739.18	71,263,986.62	184,190,107.16	17,773,530.99	3,644,059,062.88
Дансны нэвэр дүн	4,098,789,817.15	282,287,659.52	116,250,563.01	378,727,154.59	32,619,669.01	4,908,674,863.28

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

12. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийн дэлгэрэнгүй дараах байдалтай байна.:

	Санхүүгийн программ хангамж	
	2025 он	2024 он
Өртөг		
01-р сарын 01-ээр	136,000,000.00	136,000,000.00
Худалдан авалт	114,000,000.00	-
Данснаас хассан	-	-
12-р сарын 31-ээр	250,000,000.00	136,000,000.00
Хорогдуулга		
01-р сарын 01-ээр	46,280,440.00	40,280,440.00
Тухайн жилийн хорогдол	87,052,893.01	6,000,000.00
12-р сарын 31-ээр	133,333,333.01	46,280,440.00
Цэвэр дансны үнэ	116,666,666.99	89,719,560.00

13. Дансны болон бусад өглөг

(i) Дансны болон бусад богино хугацаат өр төлбөр дараах үлдэгдлээс бүрдэж байна:

(Төгрөгөөр)	2025 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
Дансны өглөг		
Дансны өглөг	422,990,968.19	62,071,602.85
Сэлбэгийн өглөг	252,832,250.00	86,867,667.54
Хөдөлмөр хамгааллын өглөг	-	6,175,350.00
Нүүрсний өглөг	-	8,875.07
Хангамжийн материал	930,500.00	2,042,700.00
Тээврийн хөлсний өглөг	143,321,485.55	129,087,794.00
Хувь хүмүүст өгөх өглөг	95,348,045.00	10,906,467.41
Дансны өглөгийн дүн	915,423,248.74	297,160,456.87
Бусад богино хугацаат өр төлбөр		
Цалингийн өглөг	-	1,754,954.00
Цайны газарт өгөх өглөг	17,520.00	3,155,491.34
Хүүгийн өглөг	-	62,699,806.14
Нийгмийн хөгжлийн сан /ҮЭ-н хураамж/	899,000.00	-
Бусад богино хугацаат өр төлбөрийн дүн	916,520.00	67,610,251.48
Дансны болон бусад богино хугацаат өр төлбөрийн дүн	916,339,768.74	364,770,708.35

Компанийн бүртгэлтэй өр төлбөрүүд нь тогтоосон эргэн төлөх хуваарьгүй бөгөөд хүүгүй болно.

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

14. Зээл

	Дуусах хугацаа	Хүү	2025.12.31	2024.12.31
Зээл ба хүүний өглөг				
Зээл 1: Голомт банк ХК – төгрөгийн зээл	3/18/2029	18.00%	2,272,781,110.24	2,500,000,000.00
Зээл 2: Голомт банк ХК – төгрөгийн зээл	6/15/2027	18.00%	448,275,862.40	689,655,172.60
Зээл 3: Голомт банк ХК – төгрөгийн зээл	-	-	-	129,792,688.00
Зээл 4: Голомт банк ХК – төгрөгийн зээл	-	-	-	464,624,731.48
Зээл 5: Голомт банк ХК – төгрөгийн зээл	6/25/2030	19.20%	1,853,658,536.60	-
			4,574,715,509.24	3,784,072,592.08

Зээл 1:

2024 оны 3-р сарын 19-ний өдөр Компани нь хөрөнгө оруулалтын зориулалтаар жилийн 18 хувийн хүүтэй, 60 сарын хугацаатай, ЗГ5805129501 дугаартай зээлийн гэрээ байгуулсан. 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл 2,272,781,110.24 төгрөг байна.

Зээл 2:

2023 оны 6-р сарын 14-ний өдөр Компани нь хөрөнгө оруулалтын зориулалтаар жилийн 18 хувийн хүүтэй, 48 сарын хугацаатай, ЗГ5805125091 дугаартай зээлийн гэрээ байгуулсан. 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл 448,275,862.40 төгрөг байна.

Зээл 3:

2025 оны 7-р сарын 8-ны өдөр Компани нь хөрөнгө оруулалтын зориулалтаар жилийн 19.2 хувийн хүүтэй, 60 сарын хугацаатай, ЗГ5805139265 дугаартай зээлийн гэрээ байгуулсан. 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл 1,853,658,536.60 төгрөг байна.

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

15. Татвар шимтгэлийн өглөг

(i) Татвар шимтгэлийн өглөг дараах үлдэгдлээс бүрдэж байна

(Төгрөгөөр)

	2025 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ХХОАТ-ын өглөг	34,926,078.84	4,019,119.82
НДШимтгэлийн өглөг	75,959.93	-
НӨАТ-ын өглөг	7,554,401.23	358,505,084.01
ААНОАТ-ын өглөг	2,888,984.55	3,593,258.04
Бусад татварын өглөг	3,363,300.00	-
ҮХХАТ-ын өглөг	4,400,000.00	4,400,000.00
Газрын төлбөрийн өглөг	320,996.00	-
АМНАТ-ын өглөг	42,146,235.13	3,940,621.00
ҮҮЗ-аар ашигласан усны төлбөрийн өглөг	7,595,390.13	-
Татвар шимтгэлийн өглөгийн дүн	103,271,345.81	374,458,082.87

16. Хувьцаат капитал

Компанийн 2024 болон 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр гаргасан нийт энгийн хувьцаа нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 536,177 ширхэг хувьцаа байна. Энгийн хувьцаа эзэмшигч нь тухай бүр зарласан ногдол ашиг авах эрхтэй бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нэг хувьцаа нэг саналын эрхтэй.

(Төгрөгөөр)

	2025 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
Энгийн хувьцаа	53,617,700.00	53,617,700.00
Халаасны хувьцаа	-	-
Эргэлтэд байгаа энгийн хувьцаа	53,617,700.00	53,617,700.00
Хувьцааны тоо хэмжээ, ширхэг	536,177	536,177
Халаасны хувьцаа, ширхэг	-	-
Эргэлтэд байгаа энгийн хувьцаа, ширхэг	536,177	536,177
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ, төгрөг	100.00	100.00

Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Нэрлэсэн үнэ	Нийт үнэ	Эзэмших хувь
Д.Мурат	421,148	100	42,114,800.00	78.55%
М.Тилеуберди	78,594	100	7,859,400.00	14.66%
Бусад хувьцаа эзэмшигчид	36,435	100	3,643,500.00	6.80%
Нийт	536,177		53,617,700.00	100.00%

(ii) Ногдол ашиг

Компани 2025 онд ногдол ашиг зарлаагүй.

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

17. Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц

(i) Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

	2025 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
01-р сарын 01-ээр	4,363,888,720.07	4,363,888,720.07
Нэмэгдсэн	6,438,278,428.67	-
Хасагдсан	-	-
12-р сарын 31-ээр	10,802,167,148.74	4,363,888,720.07

18. Борлуулалтын орлого

(i) Борлуулалтын орлогын данс нь дараах байдалтай байна

(Төгрөгөөр)

	2025	2024
Дулаан борлуулсны орлого	7,702,785,818.38	7,430,266,072.58
Борлуулалтын орлогын дүн	7,702,785,818.38	7,430,266,072.58

19. Борлуулалтын өртөг

(i) Борлуулалтын өртөг данс нь дараах данс, үлдэгдлээс бүрдэж байна.

(Төгрөгөөр)

	2025	2024
<i>Борлуулалтын өртөг</i>		
Цалин урамшууллын зардал	1,757,818,338.35	1,612,599,952.80
НДШ-ийн зардал	226,742,323.58	202,925,064.28
Мэргэжлийн үйлчилгээний зардал	40,464,116.40	68,146,737.96
Ашиглалтын зардал	1,455,071,190.68	1,235,037,975.67
Элэгдэл,хорогдлын зардал	811,437,428.50	413,353,406.81
Тээврийн зардал	1,272,427,179.00	1,082,806,258.92
Шагахууны зардал	221,708,440.00	403,247,806.89
Хөдөлмөр хамгааллын зардал	94,417,040.00	65,711,642.00
Нүүрсний зардал	1,182,860,000.00	1,303,761,694.47
Сэлбэгийн зардал	108,636,255.09	9,528,000.00
Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн дүн	7,171,582,311.60	6,397,118,539.80

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

20. Ерөнхий удирдлагын зардал

(i) Тайлант жилүүдийн ерөнхий удирдлагын зардлын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2025	2024
Албан татварын зардал	74,407,469.26	50,732,315.85
Албан томилолтын зардал	5,116,350.00	5,289,493.00
Бичиг хэргийн зардал	8,015,300.00	9,275,350.00
Шуудан холбооны зардал	26,390,283.83	29,357,651.08
Сургалтын зардал	100,000.00	4,092,500.00
Даатгалын зардал	9,127,335.00	8,518,555.00
Засварын зардал	9,894,450.00	18,163,350.00
Түрээсийн зардал	875,000.00	1,150,000.00
Харуул, хамгааллын зардал	40,450,000.00	36,930,000.00
Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал	1,109,800.00	3,217,174.00
Хүлээн авалтын зардал	82,005,774.00	55,451,221.00
Төлбөр хураамжийн зардал	46,163,491.35	31,791,689.96
Зар сурталчилгааны зардал	194,000.00	15,000.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	6,014,611.50	2,803,803.00
Бусад зардал	27,351,030.00	1,985,456.35
Дүн	337,214,894.94	258,773,559.24

21. Санхүүгийн зардал

(i) Тайлант жилийн санхүүгийн зардлын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2025	2024
Хүүгийн зардал	746,799,401.26	579,505,650.66
Санхүүгийн зардлын дүн	746,799,401.26	579,505,650.66

22. Бусад орлого, зардал

(i) Тайлант жилийн бусад орлогын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2025	2024
Бусад орлого	18,324,679.09	3,180,000.00
Бусад орлогын дүн	18,324,679.09	3,180,000.00

(ii) Тайлант жилийн бусад зардлын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2025	2024
Хандив, тусламжийн зардал	42,092,900.00	11,425,600.00
Алданги торгуулийн зардал	91,500.00	91,500.00
Үйл ажиллагааны бус зардал	17,048,650.00	-
Найдваргүй авлагын зардал	44,880,683.58	150,598,642.52
Хөрөнгө акталж устгасны зардал	63,733.29	-
Дүн	104,085,966.87	162,115,742.52

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

23. Орлогын албан татварын зардал

Компани нь санхүүгийн тайланд орлогын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын татварын зардлыг тооцдог. Компани нь 6 тэрбум төгрөг хүртэл ашгаас 10% татвар тооцдог.

	2025.12.31	2024.12.31
Орлогын албан татвар	-	3,593,258.04
	-	3,593,258.04
	2025.12.31	2024.12.31
Татвар төлөхийн өмнөх ашиг	-	35,932,580.36
Нийтлэг хувь хэмжээгээр ноогдуулсан орлого	-	35,932,580.36
10%-ийн ноогдуулсан татвар	-	3,593,258.04
Нийтлэг хувь хэмжээгээр ноогдуулсан татвар	-	3,593,258.04
Тусгайлсан хувь хэмжээгээр ноогдуулсан татвар	-	-
Тайлант үеийн орлогын албан татварын зардал	-	3,593,258.04

24. Холбоотой талууд

НББОУС 24 Холбоотой талын тодруулгын дагуу холбоотой талууд гэдэг нь нэг тал нөгөө талдаа тодорхой нөлөө үзүүлэх эсвэл санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахад нь нөлөөлдөг байхыг хэлнэ. Холбоотой талын харилцаа тус бүрийг авч үзэхэд зөвхөн хуулийн байдал бус харилцааны мөн чанар нөлөөлдөг. 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр холбоотой талууд дараах байдалтай байна:

(1) Холбоотой талтай хийсэн ажил гүйлгээ

	Ажил гүйлгээний дүн	
	2025 он	2024 он
Удирдах албан тушаалтны цалин, урамшуулал		
Гүйцэтгэх удирдлага	52,421,463.00	85,623,335.90

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

25. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын зорилтууд болон бодлогууд

Компанийн санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанийн валют, хүүгийн хувь, зээл ба төлбөрийн чадварын эрсдэлүүдийг удирдахын зэрэгцээ Компанийн хөгжлийг дэмжих санхүүгийн хүрэлцэхүйц баялагтай байх явдлыг баталгаажуулахыг зорьдог. Компанийн үйл ажиллагаа нь Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлагдсан бодлогоор тодорхойлогддог бөгөөд энэ нь ашгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэхгүй.

Компанийн гол санхүүгийн хөрөнгөд мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө болон компанийн үйл ажиллагаанаас шууд бий болсон авлага ба өглөг гэх мэт бусад санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр багтдаг.

Компанийн санхүүгийн хөрөнгөөс гаралтай эрсдэлүүд нь зээлийн эрсдэл, хүүний эрсдэл, мөнгөн урсгал болон гадаад валютын эрсдэлүүд бий. Удирдлага эдгээр эрсдэлийг удирдах бодлогыг хянадаг.

(a) Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь талуудын зүгээс хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх үед учирч болзошгүй алдагдлыг хэлнэ. Үйлчлүүлэгчид болон харилцагч талууд хугацаа нь дуусаж хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зах зээлийн таагүй нөхцөл байдлаас шалтгаалан алдагдал гарч болзошгүй тул энэ нь бизнесийн онцлог шинж чанартай байдаг.

Харилцагчийн зээлийн эрсдэлийг Компанийн тогтоосон бодлого, үйл явц болон харилцагчийн зээлийн эрсдэлийн удирдлагын хяналтын дагуу удирддаг. Харилцагчийн зээлийн чанар нь зээлийн түүх дээр үндэслэн үнэлэгддэг бөгөөд хувь хүний зээлийн хэмжээ нь энэ үнэлгээгээр тодорхойлогддог. Компани нь харилцагчийн дансны авлагад тогтмол хяналт тавьдаг.

Чанаргүйдлийн тодорхойлолт

Үйлчлүүлэгчийн үлдэгдэл гэрээний төлбөрөөс 90 хоног хэтэрсэн тохиолдолд Компани нь санхүүгийн хэрэглүүрийг чанаргүй болсон бөгөөд үнэ цэнэ нь буурсан гэж үзсэн.

Компанийн төлбөрийн чадваргүй болох магадлал тооцох үйл явц

СТОУС 9-ийн хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвар нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн банкны хадгаламж болон худалдааны авлагад хамаарна.

Үйлчлүүлэгчдээс авах авлагын үнэ цэний бууралтын үнэлгээ

Компани нь зээлийн алдагдлын нөөцийн түүхэн түвшнийг ашиглаж, сар бүрийн инфляцын түвшнийг макро эдийн засгийн хүчин зүйл болгон авч үзэж, ирээдүйн төлбөрийн чадваргүй болох магадлалыг тооцсон.

Компани нь ЧМ-г тооцоолохдоо ирээдүйг илтгэх мэдээллийг ашиглан ирээдүйн макро эдийн засгийн өөрчлөлт ҮЦХА-д хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж үздэг. Энгийн шугаман хамаарлын аргыг ашиглан ажиглагдахуйц чанаргүйдлийн /дефолтын хувь болон макро эдийн засгийн хүчин зүйл хоорондын харилцан хамаарлыг тооцдог. Компанийн хувьд инфляцын түвшин нь хамгийн оновчтой макро эдийн засгийн хүчин зүйл гэж үзсэн.

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

25. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын зорилтууд болон бодлогууд, Үргэлжлэл

Чанаргүйдэлд өртөх дүн

Чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД) нь харилцагчийн алдагдал хүлээх дүн болон эрт эргэн төлөлт хийх чадвар зэргийг харгалзан үзэж санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ буурах үед тооцсон бодит хэмжээг хэлнэ.

ҮЦХА-ын загварын өгөгдөлд дүн шинжлэгээ хийх нь

ҮЦХА-ыг тооцох аргын тоймыг Тодруулга 2 (Нягтлан бодох бүртгэлийн товчоо), болон Тодруулга 3 (Нягтлан бодох бүртгэлийн гал үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд)-д мэдээлсэн байгаа. Бүрэн, үнэн зөв байдлыг хангахын тулд Компани нь гуравдагч этгээдийн эх сурвалжаас (жишээ нь, Монгол банк, Үндэсний статистикийн хороо гэх мэт) ашигласан өгөгдлийг авч, олон хувилбарт хамаарах жинг тодорхойлох зэрэг Компанийн ҮЦХА загварт үнэн зөвийг баталгаажуулдаг.

Компанийн санхүүгийн хэрэгслийн зээлийн эрсдэлийн дээд хэмжээ нь санхүүгийн тайланд тодруулсан дансны дүнтэй тэнцүү байна.

(b) Хүүний түвшний эрсдэл

Хүүний түвшний эрсдэл нь хүүгийн түвшний өөрчлөлт санхүүгийн хэрэглүүрийн ирээдүйн мөнгөн урсгал эсвэл бодит үнэ цэнд нөлөөлж болох эрсдэл юм.

Хүүний түвшний өөрчлөлтийн улмаас зах зээлийн эрсдэлд орлог ба энэ нь голдуу Компанийн хадгаламжийн дансны хүүнээс шалтгаалдаг. Удирдлага нь энэхүү эрсдэлийг Компанийн хувьд ач холбогдолгүй гэж үздэг тул Компанид хүүгийн эрсдэлийг удирдах талаар албан ёсны бодлого, журам байхгүй.

(c) Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл нь Компани нь санхүүгийн өр төлбөрөө барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэл үүсэх эрсдэлийг илэрхийлнэ. Компани нь өөрийн бүх эргэн төлөлт ба санхүүжилтийн хэрэгцээ хангагдаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд өөрийн үйл ажиллагааны мөнгөн урсгал ба санхүүжилтийг идэвхтэй удирддаг. Компани нь ажлын капиталын шаардлагуудыг хангахад хүрэлцэхүйц хэмжээний бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг байршуулдаг.

Доорх хүснэгт нь гэрээний хөнгөлөгдөөгүй төлбөр дээр үндэслэсэн Компанийн санхүүгийн өр төлбөрийг төлөх хугацааг харуулсан байна:

2025 оны 12-р сарын 31-ээр	Нэг жилийн дотор	Нэг жилээс дээш	Нийт дүн
Санхүүгийн өр төлбөр			
Дансны болон бусад богино хугацаат өр төлбөр	916,339,768.74	-	916,339,768.74
Зээлийн өглөг	795,993,571.80	3,778,721,937.44	4,574,715,509.24
Дүн	1,712,333,340.54	3,778,721,937.44	5,491,055,277.98

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

25. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын зорилтууд болон бодлогууд, Үргэлжлэл

(d) Гадаад валютын эрсдэл

Компани нь гадаад валютын ханшийн өөрчлөлтөд өртөх бусад гадаад валютаар гүйлгээ хийдэггүй.

26. Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн тооцоолсон бодит үнэ цэнэ нь үндсэндээ эдгээр хэрэглүүрийн богино хугацааны дуусах хугацаанаас шалтгаалж дансны үнэтэй ойролцоо байна гэж удирдлага үнэлэв.

Компани санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тодорхойлж, тэдгээрийн тодруулгыг бэлтгэхэд хэрэглэсэн нөлөө бүхий мэдээний ангиллаас хамааралтайгаар дараах шатлалыг ашигласан болно.

Шатлал 1: Ижил төрлийн хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн жишиг үнэ (залруулаагүй)

Шатлал 2: Шатлал 1-д заасан зах зээлийн жишиг үнээс бусад өгөгдөл. Энэ нь жишиг болохуйц хөрөнгө, өр төлбөрийн шууд (жишээ нь: үнэ) болон шууд бус (шууд бус: үнүүдийн нийлбэр) өгөгдөл байна

Шатлал 3: Зах зээлийн мэдээлэл байхгүй нөхцөлд хөрөнгө, өр төлбөрийн бусад өгөгдөл

Компани нь бодит үнэ цэнээрээ тайлагнагдаагүй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг дараах арга зүйг ашиглан тодорхойлдог.

Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо байдаг санхүүгийн хөрөнгө

Түргэн борлогдох болон нэг жилээс богино хугацаанд дуусах санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд богино хугацаанаасаа шалтгаалан дансны үнэ нь ойролцоогоор бодит үнэ цэнтэй ижил байдаг.

Санхүүгийн хэрэглүүр

Хорогдуулсан өртгөөр бүртгэлд тусгагддаг тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо тэдгээрийг анх гаргах үеийн зах зээлийн хүүгийн хувийг зах зээл дээр байгаа ижил төстэй санхүүгийн хэрэгслийн одоогийн үнэ ханштай харьцуулдаг.

ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ ХК
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

26. Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ, Үргэлжлэл

Дансны үнийг бодит үнэ цэнтэй харьцуулах нь

тогтоогоор

	2025		2024	
	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн хөрөнгүүд				
Дансны болон бусад авлага	4,936,826,084.68	4,936,826,084.68	2,003,959,055.29	2,003,959,055.29
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	99,089,453.99	99,089,453.99	817,147,575.56	817,147,575.56
	5,035,915,538.67	5,035,915,538.67	2,821,106,630.85	2,821,106,630.85
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн өр төлбөрүүд				
Дансны болон бусад богино хугацаат өр төлбөр	1,712,333,340.54	1,712,333,340.54	1,518,617,898.82	1,518,617,898.82
Урт хугацаат зээл	3,778,721,937.44	3,778,721,937.44	2,630,225,401.62	2,630,225,401.62
	5,491,055,277.98	5,491,055,277.98	4,148,843,300.44	4,148,843,300.44

Хүүгийн түвшний эрсдэл

Компанийн хүү тооцогдох санхүүгийн хөрөнгүүд нь ихэнхдээ тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгүүд байгаа тул орлого болон үйл ажиллагааны мөнгөн урсгал нь зах зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтөд өртөх нь бага байдаг.

Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь санхүүгийн өр төлбөрөөс бий болох үүрэг хариуцлагыг мөнгө эсвэл бусад санхүүгийн хөрөнгөөр барагдуулахад компанид учрах аливаа эрсдэлүүд юм.

Мөнгөн урсгалын хэлбэлзлийг бууруулах, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон санхүүгийн хэрэгслийн тоо хэмжээг тодорхойлох замаар компани хөрвөх чадварын эрсдэлээ хянаж, удирддаг. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан гарсан өдрөөс хойш 12 сарын хугацаанд компани ирээдүйд гарах гэрээний төлбөрүүд болон бизнесийн явцад үүсэж байдаг өр төлбөрүүдийг төлөх хангалттай хэмжээний эргэлтийн болон капиталын хөрөнгөтэй гэж үзэж байгаа.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

26. Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ, Үргэлжлэл

Капиталын удирдлага

Компани нь өр төлбөр болон өмчийг оновчтой зохицуулах замаар хувьцаа эзэмшигчдэд бий болох өгөөжийн түвшнийг хамгийн их хэмжээнд байлгахын сацуу компанийн тасралтгүй үйл ажиллагааг хангах байдлаар капиталаа удирддаг.

төгрөгөөр

	2025	2024
Нийт өр төлбөр	5,595,195,649.79	4,524,170,409.31
Нийт өмч	10,218,175,907.43	4,418,137,056.04
Өрийн харьцаа	55%	102%

27. Болзошгүй өр төлбөр

(1) Хууль, эрх зүй

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад компанид хуулийн арга хэмжээ авах болон гомдол хүлээн авах зэрэг асуудлууд тулгардаг. Ийм асуудлаас үүдэж болох компанийн хариуцлага нь компанийн санхүүгийн байдал болон ирээдүйн үйл ажиллагаанд материаллаг түвшинд сөргөөр нөлөөлөхгүй гэдэгт компанийн удирдлага итгэлтэй байна.

(2) Болзошгүй өр төлбөр

Компанид санхүүгийн тайлангийн өдрөөр санхүүгийн тайланд тодруулагдах буюу залруулагдах шаардлагатай болзошгүй өр төлбөр болон үүрэг хариуцлага байхгүй байна.

Зн №	Алдны үгс	Дансны нэр	Дансны код	Дойн	(Курс)	Дансны гүйцэтгэл наймаа	Баланс үзүүлэлт, Дойн, Дойн	
							Дойн	Ор шалбар
SUAM 1	Борьд материалын алдны ангилал зөрүүлэн бүртгэгдсэн байна	Машина, хэрэгсэл, хөдөөжил	20-0300	22,757,250.00	96,019,440.00			
		Сэлбэг хэрэгсэл	14-0303		2,311,000.00			
		Ашигласнад байгаа материал	14-0304	55,557,466.00	32,000.00			
		Бусад материал	14-0305		6,273,805.00			
		Бусад хөрөнгийн материал	14-0306	6,096,505.00	82,000.00			
SUAM 2	Зардалын ангилал зөрүүлэн бүртгэгдсэн байна	Бусад зардал	74-0500	12,452,400.00	9,501,750.00			
		Мэргэжлийн үйлчилгээний зардал	70-0700	3,309,000.00	2,860,650.00			
		Засварын зардал	70-1200		3,300,000.00			
		Хүснэгт аяллын зардал	70-1900					
		Төсбэр хууцаарчдын зардал	70-2300					
SUAM 3	Зардалын ангилал зөрүүлэн бүртгэгдсэн байна	Цэвэрлэх зардал	70-0100	4,100,000.00	4,100,000.00			
SUAM 4	Самууныг хайгуурлах, барилдсан бүтээгдэхүүний өртний өртний ба уламжлалын зардалын төсвийн үнэ байгаа	Урт хугацааны зардал	74-0100	7,178,982,311.60	7,178,982,311.60			
		Борлуулалтын өрт						
		Ашигласнад байгаа борлуулалтын өрт	14-0301	15,874,616.74	731,183.50			
		Борлуулалтын зардал	20-0200	1,584,000.00	22,954,545.69			
		Борлуулалтын зардал - Эхний	20-0601	81,396,519.00	111,599,218.00			
SUAM 5	Уламжлалын ангилал зөрүүлэн бүртгэгдсэн байна	Борлуулалтын зардал	20-0500	36,029,411.45				
		Төсвийн зардал	20-0501					
		Төсвийн зардал - Эхний						
		Бусад зардал-Хүснэгт аялал	70-1900	79,145,134.00	79,145,134.00			
		Хүснэгт аялалын зардал-БҮГД						
SUAM 7	Урт хугацааны зардалын ангилал зөрүүлэн бүртгэгдсэн байна	Борлуулалтын зардал	35-0100	502,256,307.44	502,256,307.44			
				5,029,700,000.00	5,029,700,000.00			

Баталсан: Солонг Юнгийн Аудит ХХК

Баталсан: Эрхэмлэлтийн үнэ ХХК

З.Мунгун
Гүйцэтгэл

М.Түвшин
Гүйцэтгэл

У.Цэвэр
Аудитор

К.Борхон
Борлуулалтын байр